



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/А63

Булган сум


**Аймгийн 2025 оны шинэ жилийн баярын
арга хэмжээг зохион байгуулахад
хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Аймгийн шинэ жилийн баярын хүрээнд зохион байгуулагдах “Оны шилдгүүдийг шалгаруулах” ёслолын арга хэмжээний тоглолтод шаардлагатай хэрэглэгдэхүүн, материал болон Цогт хунтайжийн талбайд шинэ жилийн уур амьсгал бүрдүүлэх гэрэлтүүлэг, чимэглэл, тохижилтын зардалд 77,825,000 (далан долоон сая найман зуун хорин таван мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Баярын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс 21,000,000 (хорин нэгэн сая), 56,825,000 (тавин зургаан сая найман зуун хорин таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
 12 дугаар сарын 09-ны ний өдрийн
 А/ЗББ дугаар захирамжийн хавсралт

2025 оны аймгийн шинэ жилийн арга хэмжээг
 тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах зардал

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
Урлаг, уран бүтээлийн хувцасны зардал					
1	Дуучдын даашинз	3	ш	500,000	1,500,000
2	Эрэгтэй хослол (смоке)	3	ш	600,000	1,800,000
3	Өвлийн өвгөний иж бүрэн хувцас	1	ш	1,600,000	1,600,000
Нийт				4,900,000	
Цогт хунтайжийн талбайн сүлд мод, чимэглэл, тохижилтын зардал					
1	Сүлд мод (10м өндөр)	1	ш	19,375,000	19,375,000
2	Гэрлэн чимэглэл	Багц	-	19,750,000	19,750,000
Нийт				39,125,000	
Бусад					
1	Тэнгэрийн салют	3 мин	-	6,000,000	6,000,000
2	Тайзны салют	5	ш	200,000	1,000,000
3	“Мөсөн хотхон” болзолт уралдааны зардал	-	-	10,000,000	10,000,000
4	Талбайн хоёр талын модны суурь ороох (1ш 50м)	45	ш	40,000	1,800,000
5	Гарын бэлэг (хүүхэд)	300	ш	50,000	15,000,000
Нийт				33,800,000	
Нийт дүн				77,825,000	
Үүнээс		Төсөл, арга хэмжээний зардал		56,825,000	
		Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө		21,000,000	